

Ю.ЦЭДЭНБАЛ МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛЫН АСУУДАЛД ХЭРХЭН ХАНДАЖ БАЙСАН ТУХАЙ

Ц.Гүрбадам*

Монгол Улсыг ЗХУ-д нэгтгэх саналыг нам төрийн зүтгэлтнүүд хэд хэдэн удаа тавьж түүнийг яаж шийдвэрлэх талаар хэрхэн хандаж байсан маш нууцлагдсан асуудлуудын тухай өгүүлнэ.

“Хүйтэн” дайны үеийн Монгол Улсын түүхийн аливаа асуудал улс орны удирдлагын бүхий л өндөрлөгүүдийн жолоог бараг хагас зуун жил атгаж байсан түүхэн хүн Ю.Цэдэнбалын үйл ажиллагаатай шууд холбоотой. Ялангуяа эх орныхоо тусгаар тогтнолын асуудалд Ю.Цэдэнбал хэрхэн хандаж байсан нь судлаачдын анхаарлыг татсаар ирсэн боловч одоо болтол нэгдсэн нэг дүгнэлтэд хүрч чадахгүй байгаа юм. 1921 оны хувьсгалын дараа монголчууд тусгаар тогнолоо тунхаглаж Зөвлөлт Орос улстай дипломат харилцаатай болсон явдал (Де-факт)-ыг Дундад иргэн улс эсэргүүцэж 1946 оны нэгдүгээр сар хүртэл БНМАУ-ыг өөрийн бүрэлдэхүүн хэсэг гэж үзсээр байсан билээ. Гэвч 1945 оны 2 дугаар сард холбоотон гүрнүүдийн Ялтад хийсэн Бага хурлаас “Тадаад Монгол (БНМАУ)-ын статус-кво” тогтоон тохиролцсоны зэрэгцээ Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн нөхцөлд л Японы эсрэг дайнд оролцох болно гэсэн шаардлагыг Рузвельт, Чан Кайши хоёрт И.Сталин тулган тавьж гарцаагүй байдалд оруулсны үр дүнд Гоминданы засгийн газар 1946 оны нэгдүгээр сарын 6-ны өдөр БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч улмаар 2 дугаар сарын 10-нд дипломат харилцаа тогтоосон юм.

БНМАУ-ын тусгаар тогтнолын асуудал 25 жилийн турш хоёрдмол утгатай байснаа ийнхүү <<Де-юре>> болсны дараа ч эх орноо тусгаар улс хэвээр нь байлгах

* МУИС, ОУХС-ийн профессор, доктор (D.Sc)

уу, эсхүл бусад улсад нэгдсэн нь дээр үү гэсэн бодол, эрэгцүүлэл монголчуудад байсан төдийгүй тун өндөр түвшинд яригдаж, ЗХУ-д сайн дураар нэгдэн орох нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрч байсан ажээ.

Энэ тухай Монголын олон нийт мэдэхгүй явж ирсэн боловч 1989-1990 оны үед ардчилал, ил тод байдал, олон урьгалч үзэл буй болж өрнөсний ачаар өмнө нь нууцлагдаж байсан зарим баримтууд ил гарч судлаачид өөрсдийн бодол санааг илэрхийлдэг болсон билээ. Дээрх асуудлаар түүхчид, улс төрчид, сэтгүүлчид тэр үед үнэмшихэд бэрх олон зүйл хэвлэн нийтлүүлж байсныг нэн хураангуйлж тодорхойлбол, нэг хэсэг нь “Ю.Цэдэнбал бол Монгол улсыг ЗХУ-ын 16 дахь республик болгох гэсэн урвагч” гэж хараан зүхэж байхад нөгөө хэсэг нь “Х.Чойбалсан улс орноо ЗХУ-д нэгтгэн оруулахын эсрэг тууштай байр суурьтай байсан. Иймээс ч Кремлийн заавар, шахалтаар 40 гаруй мянган иргэнээ хэлмэгдүүлэн амь насыг нь хороож И.Сталины “аманд” Монгол улсаа оруулалгүй тусгаар тогтнолоо хамгаалж чадсан юм” гэж магтан сайшаасан байдаг. Эдгээр нь түүхэн үнэнийг гуйвуулж улс төр, үзэл суртлын үүднээс хэт туйлшруулсан хандлага байсан гэдэг нь сүүлийн үеийн судалгаануудаас тодорхой болсоор байна. Эдүгээ ил тод болсон архивын материал тун ховор боловч Ю.Цэдэнбалын хүү Ц.Зоригийн “Сүүлчийн долоон жил.1993 он”, ЗХУ-ын дипломатч, доктор, монгол судлаач Ш.Г.Надиоровын 1995 онд нийтлүүлсэн “Цеденбал 1984 год”, мөн манайд албан ёсны анхны мэдээлэл болсон “Гэрэл сүүдэр: Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс. 1992 он” зэрэг ном, зохиолуудад сонирхол татсан баримтууд цөөнгүй байдаг. Мөн миний бие “Ю.Цэдэнбал: Түүхэн үнэний тухай бодрол” номоо 1994 онд хэвлүүлэхдээ нилээд баримт, сэлтийг сурвалжлан олж ашигласан билээ.

“Хүйтэн” дайны үеийн Монгол улсын түүхийн зарим нууц асуудлыг Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс олж үзэх боломжтой болсныг энэ дашрамд цохон тэмдэглэе. Тэр үеийн Монгол улсын удирдагч байсан Ю.Цэдэнбалыг бүх албан тушаалаас нь өөрчлөх асуудал хэлэлцэх хурал болохоос гурван хоногийн өмнө 1984 оны 8 дугаар сарын 20-ны өдөр тэрбээр ЗХУ-ын Коммунист Намын Төв Хороонд хандаж захидал бичсэн агаад түүн дотор хоёр орны харилцааны маш нарийн, ээдрээтэй асуудлуудыг лав тусгасан байх гэсэн найдлага төрдөг. Гэвч тэр үед Ю.Цэдэнбалын сэтгэх чадвар ихээхэн сул дорой болоод байсан тул ОХУ-ын нэгэн сэтгүүлч түүний гэргий А.И.Филатова-Цэдэнбалын хэлсэн жижиг сажиг

зүйлийг захидал мэтээр бичсэн байж ч магадгүй. Иймд жинхэнэ эх сурвалжийг үзэж нягтлан дүгнэх ёстой.

Монгол улсыг И.Сталин ЗХУ-д нэгтгэж авах аюулаас Х.Чойбалсан улс орноо аварч тусгаар тогтнолоо хамгаалж чадсан юм гэж үздэг хүмүүс чухамдаа түүхэн үнэнийг хэт гуйвуулж И.Сталины геостратегийн холч бодлогыг огтхон ч ойлгоогүй болохыг хэд хэдэн баримт харуулж байна. И.Сталин Гадаад Монгол буюу БНМАУ-ыг ЗХУ-ын 16 дахь республик болгох бодлого явуулах байтугай тийм үг ч дуугарч байгаагүй бөгөөд харин монголчууд ийм саналыг өөрснөө түүнд хэд хэдэн удаа тавьж байсан баримт байгаа юм. Тухайлбал, Маршал Х.Чойбалсаныг амьд сэрүүн байхад Салчик Токагаар удирдуулсан Бүгд Найрамдах Тува Ард улс ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнд багтан орохоор шийдвэрлэсэн 1944 оны долдугаар сард МАХН-ын Төв Хорооны улс төрийн товчооны гишүүн, Улсын Ерөнхий прокурор Б.Жамбалдорж Улс Төрийн товчоонд албан ёсоор тавьсан саналдаа: "Манай Монгол Улс Зөвлөлтийн аугаа их гэр бүлд багтах нь манай улсын цаашдын түргэн хөгжилд их л утгатай бөгөөд цаг нь болсон асуудал гэж би бодно. Зөвлөлтийн ард түмний эх орны дайны хүнд байгаа цагт монголын ард түмнээс ийм санал гаргахад манай хоёр улсын ах дүүгийн харилцаа, найрамдал аль хэр бат бэх байгааг үзүүлэх нэгэн фактор болох юм. Зөвлөлтийн гэр бүлд багтах гэдэг санал бол гагцхүү над байгаа бус олон түмэнд байгаа юм"¹ гэх зэргээр үзэл бодлоо илэрхийлж байжээ. Дайны хүнд хэцүү цагт хэсэг улс төрчдийн дотор буй болсон энэхүү санал дайн дууссанаас хойш 5 жилийн дараа дахин яригдаж, 1950 оны 8 дугаар сард Д.Төмөр-Очир, Л.Цэнд тэргүүтэй зургаан сэхээтэн улс орныхоо хөгжлийн зарим чухал асуудлыг лавлан асууж тодорхой хариулт авахыг хүсэн Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал хоёрт захидал бичжээ. Уул захидалд дэвшүүлсэн 9 асуудлаас гадна өөрсдийн үзэл бодлоо жич бичиж хавсаргасан бөгөөд түүнд "Монгол улсад социалист нийгмийг бүрэн байгуулахын тулд материал-техникийн хүчирхэг баазтай байх ёстой. Тийм баазыг бидэнд гагц Зөвлөлтийн аж үйлдвэр тавьж өгөх ёстой. Гэхдээ бид Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд багтан орсон тухайд тийм баазтай болж чадна. Нэгэнт учир ийм болоход манай улс өөрийн амьдрал ба хөгжлийн шаардлагаар эрт орой хэзээ боловч тэрхүү холбоонд багталцан орох нь гарцаагүй болж ирнэ"² гэж бичсэн байв.

¹ Л.Бат-Очир. Чойбалсан (намтарын нь балархайг тодруулахуй ...) Улаанбаатар 1996 он. 68 дахь тал.

² Д.Дамбын ярилцлага <<Үнэн>> сонин. <<Новости Монголии>> сонин. 1991-03-31.

Тэдний энэхүү үзэл баримтлал, саналыг Х.Чойбалсан эхний үед Б.Жамбалдоржид хандсан шигээ эрс зэмлэн буруушааж байсан бол Ю.Цэдэнбал харин ч дэмжиж бас л зэмлүүлж байжээ. Тэрбээр, ЗХУ-ын бүрэлдэхүүнд сайн дураар багтан орох нь социализм байгуулах хамгийн найдвартай дөт зам гэсэн санал, бодлыг дэмжиж “Хэрэв чингэвэл, монгол үндэстэн мөхөж сөнөхгүй төдийгүй, харин ч эдийн засаг, соёлын талаар цэцэглэн хөгжиж чадахыг Зөвлөлтийн холбооны улсуудын жишээ тодорхой харуулж байна шүү дээ” гэж учирлахад нь Чойбалсан уурлаж “Төр улс нь устчихавал, яваандаа үндэстэн ястан нь устахгүй яах вэ?”³ хэмээн эрс эсэргүүцэн няцааж байжээ. Гэхдээ Х.Чойбалсан үнэхээр тийм хатуу байр суурьтай байсан уу, эсхүл хамтран зүтгэгчдээ сорьж сонжиж байв уу гэж бодогдуулах нэг учир шалтгаан буй. Тэр нь юу вэ гэвэл Чойбалсан 1942 оны 11 дүгээр сард Бүх холбоотын коммунист большевикуудын (БХК(б)) намд элсэхээр И.Сталины нэр дээр өргөдөл гаргасан улс төрийн шийдэл юм. Тэр захидал олдвол яагаад ийм өргөдөл гаргасан нь улам тодорхой болох ёстой.

Ийнхүү өргөдөл гаргасныхаа дараа 1944 оны 1 дүгээр сарын сүүлчээр Х.Чойбалсан Кремльд И.Сталинтай уулзаж хэлэлцээр хийхдээ Монголын баруун урд хилийн дагуу оршин суудаг казах, монгол, уйгар үндэстнүүдийг Гоминданы Хятадын дарангуйллаас чөлөөлж тусгаар тогтнож байсан уламжлалыг нь дахин сэргээхэд Монгол улс хэрхэн хандах тухай санал солилцож цэргийн зэвсэг, техникийн тусламж тэдэнд үзүүлэх шийдвэр гаргасан байна.

Тэр үеэр И.Сталин хэлэхдээ: “Чойбалсан бол ганцхан Гадаад Монголын удирдагчаар зогсохгүй, мөн нэгэн адил Дотоод Монголын удирдагч мөн”⁴ гэж байжээ. Энэ үгийн утга санааг одоо эрэгцүүлэн бодоход Дундад иргэн улсад ихээхэн нутгаа алдсан хоёр гүрний (Монгол, ЗХУ) удирдагчид түүнийгээ эгүүлэн авах ёстой гэсэн далд санааг дотроо агуулж байсан тул Алтай орчмын нутагт Гоминданыхны эсрэг тэмцэж байсан казах Оспаныг эхлээд маршал Х.Чойбалсангаар дэмжүүлж зэвсэгт тулалдааныг идэвхжүүлээд ямар үр дүнд хүрэхийг нь харах гэсэн И. Сталины тактик байсан болов уу. Ар, Өвөр Монголын удирдагч хэмээн И.Сталин түүнийг үнэлсэнд нь ч юмуу, ах дүү монголчуудаа эрх чөлөөтэй болгох гэсэндээ ч юм уу, Х.Чойбалсан Москвагаас нутагтаа эргэж ирмэгцээ 2 дугаар сард нутгийнхаа баруун урд хязгаарт очиж Хятадаас салан тусгаарлах үзэлтэй Оспантай уулзаж ЗХУ-аас авсан зэр зэвсгээ

³ Д. Дамбын ярилцлага, <<Үнэн>> сонин. <<Новости Монголии>> 1991-03-31

⁴ Л.Бат-Очир. Чойбалсан (намтарын нь балархайг тодруулахуй ...). Улаанбаатар. 1996 он 168 дахи тал

түүнд өгч олон зүйлийг хэлэлцэн тохиролцсон боловч сүүлдээ асуудал огт өөрөөр эргэж хоёр тал хоорондоо зэвсэгт мөргөлдөөн хийснээр Х.Чойбалсан, И.Сталин нарын далд бодол хэрэгжиж чадалгүй талаар өнгөрсөн юм.

Гэвч Ар, Өвөр Монголыг нэгтгэх санаа, мөрөөдлөө Х.Чойбалсан өөрчлөөгүй бөгөөд түүнийг нь И.Сталин дэмжсээр байжээ. Жишээлбэл, Х.Чойбалсан сүүлчийн удаа 1949 оны 9 дүгээр сарын 30-нд Сочид И.Сталинтай уулзахдаа “Хэрэв Дотоод Монгол манай улстай нэгдвэл яваандаа СССР-ийн холбооны улс болоход болох уу?”⁵ гэж асуухын хамт БНМАУ-ыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах тухай Б.Жамбалдоржийн 1944 онд бичсэн дээрх захидлын талаар зөвлөгөө авч байжээ. Хоорондоо нилээд нарийн ялгаатай энэ хоёр асуудлын талаар И.Сталин хэлэхдээ: “Танайх манай холбооны улс болох хэрэггүй. Бид Гадаад, Дотоод хоёр Монголыг нэгдэхийг дэмжихдээ Оросын харьяанд ч орохгүй, Хятадын харьяанд ч орохгүй нэгдсэн нэгэн тусгаар улс байхыг хүсэж байна”⁶ гэж зөвлөжээ. Энэ нь үнэн хэрэгтээ ямар ч ач холбогдолгүй, цаг үеэ алдсан үг байсан гэж хэлж болно. Учир нь гэвэл, яг тэр мөчид Мао Зедун БНХАУ байгуулагдсаныг дэлхий нийтэд тунхаглаж байсан билээ.

И.Сталинтай олон жил ажиллаж тэр үеийн хэт их гүрэн ЗХУ-ын гадаад бодлогыг хамтран боловсруулж хэрэгжүүлдэг байсан В.Молотов Н.Хрущевын үед огцроод Монгол улсад Элчин сайдаар ажиллаж байхдаа манай ГЯЯ-ны сайд Аварзэдтэй Давст уулын асуудлаар санал зөрж маргалдах үедээ: “Та нар алгын чинээ газрын төлөө их юм болох юм. Ингэж ярихад хүрвэл, танай маршал Чойбалсан чинь тухайн үед Монгол улсыг Зөвлөлтөд нэгтгэхийг гурван ч удаа хүсэж байсан явдал бий шүү”⁷ хэмээн мэдэгдэж байсан гэдэг.

Миний бие 1950-аад оны эхээр ЗХУ-д суралцаж байхад Зөвлөлтийн хүмүүс: <<Танай маршал Чойбалсан ЗХУ-д нэгдэж орох санал тавьсан гэнэ лээ. Хэдийд манай 16 дахь республик болох гэж байна вэ?>> хэмээн асуудаг байсан. Надаас гадна олон монгол хүн ийм асуулт сонссон гэж хэлэхэд хэтрүүлэг болохгүй бизээ.

Энэ бүгдээс үзэхэд И.Сталин Монгол улсыг өөртөө нэгтгэж авах гээгүй, харин манай талаас ЗХУ-ын бүрэлдэхүүнд орох саналыг нэг бус удаа тавьж байсан нь тодорхой бөгөөд эцсийн дүнд Ар, Өвөр хоёр Монголыг ч нэгтгэх бодлого, төлөвлөгөө түүнд байгаагүй гэдэг нь олон баримтаар нотлогдож байгаа юм. Тэрбээр 1945 онд

⁵ Л.Бат-Очир. Чойбалсан (Намтрын балархайг тодруулахуй ...) Улаанбаатар. 1996 он 168 дахи тал

⁶ Мөн тэнд 187 дахи тал

⁷ Ц.Гүрбадам. Ю.Цэдэнбал: Түүхэн үнэний тухай бодрол. Улаанбаатар. 1994 он. 211 дэх тал

Гадаад Монгол буюу БНМАУ-ын “статус-квог” холбоотон гүрнүүдтэй хэлэлцэн тохирсон, улмаар 1946 онд Чан Кайшигаар БНМАУ-ын тусгаар тогтнолыг тэр үеийн хилээр хүлээн зөвшөөрүүлсэн, мөн 1945 оны 8 дугаар сарын 10-нд Японы эсрэг дайнд оролцохдоо дайны дараа <<...бүх Монголчуудыг эрх чөлөөтэй, тусгаар тогтносон, бүрэн эрхт нэгэн ах дүү улс гэр болгон нэгдүүлэх явдлыг хангах болно>> гэсэн зорилго Х.Чойбалсан дэвшүүлснийг мэдсээр байсан атлаа түүнийгээ хэрэгжүүлж эхэлсэн анхны арга хэмжээг нь Мао Зедүний хүсэлтээр таслан зогсоосон зэрэг бодит үйл явдлууд үүнийг нотлох бизээ.

Ийм улс төр, дипломатын том шийдэл, тохиролцоонд хүрсэн атлаа БНМАУ-ыг 1949 онд тунхаглаж байсан тэр цаг мөчид Х.Чойбалсанг Ар, Өвөр Монголын хоёулангынх нь удирдагч гэж өргөмжилж үг хэлсэн нь нэн гайхалтай, бас тэр үеийн түүхэн үйл явдлын бодит байдалтай ямар ч холбоо уялдаагүй хоосон үг байсныг манай улсын удирдагч ухааралгүй өнгөрсөн нь бүр ч харамсалтай.

1952 онд Х.Чойбалсан, 1953 онд И.Сталин нас нөхчсөний дараа Ю.Цэдэнбал болон Зөвлөлтийн шинэ удирдагчид БНМАУ-ыг ЗХУ-д нэгтгэх асуудалд хэрхэн хандах болсон бэ гэсэн асуулт аяндаа гарч ирэх ёстой. Түүхэн хугацааны явцад энэ ээдрээтэй эмзэг асуудал янз бүрийн өнгө аястай болж байсныг тэмлэглэхийн хамт цөөн баримтаар тодруулан тайлбарлая.

ЗХУ-ын бүрэлдэхүүнд орох саналыг 1950 онд Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нарт бичиж байсан Д.Төмөр-Очир, Л.Цэнд тэргүүтэй сэхээтнүүд Х.Чойбалсаныг өөд болсны дараа дээрх хүсэлтээ Ю.Цэдэнбалд дахин тавьсан байна. Уул санал хүсэлтийг нь 1953 оны 3 дугаар сарын эхээр НТХ-ын Улс төрийн товчоогоор хэлэлцээд сайшаан дэмжсэн тогтоол гаргахаар шийдвэрлэж байсан бололтой. Тэр тогтоол нь эдүгээ олдохгүй байгаа хэдий ч утга агуулга нь ямар нэг хэлбэрээр ЗХУ-ын дээд удирдлагуудад хүрсэн байжээ.

Гэхдээ тийм тогтоол үнэхээр гарсан эсэх талаар Монгол, Оросын судлаачид санал зөрүүтэй байгаа юм. Тухайлбал, доктор (Sc.D) Л.Бат-Очир: <<Товчооны зарим гишүүд нааштай шийдвэр гаргахаас татгалзаж, зарим нь түүнийг Намын Төв Хорооны бүгд хурал, Ардын Их Хурлын чуулганд оруулан хэлэлцэхийг шаардсан боловч голлох хүмүүсийн зүтгэснээр уг асуудлыг сайшаасан тогтоолын төслийг яаруу тэвдүү <<боловсруулж>> ЗХУКН-ын Төв Хороонд хүргүүлжээ>>⁸ гэж бичсэн байна.

⁸ Л.Бат-Очир. Чойбалсан (Намтрын нь балархайг тодруулахуй ...). Улаанбаатар. 1996 он. 72 дахи тал

Гэтэл ЗХУ-ын ГЯЯ-ны орлогч сайд асан хятад судлаач, доктор, профессор М.С.Капица: “Ю.Цэдэнбал Москва руу нисэхийнхээ өмнөхөн гэнэт ийм тогтоол гаргаж болохгүй тухай шийдвэр өгсөн⁹ гэж бичсэн байдаг. Мөн ЗХУ-ын дипломатч, монгол судлаач, доктор Ш.Г.Надиров : <<Тэр үед МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга төдийгүй БНМАУ-ын Ерөнхий сайд, өөрөөр хэлбэл улсын тэргүүн болоод байсан Ю.Цэдэнбал уул тогтоолын санааг идэвхтэй дэмжиж байсан бөгөөд тогтоолын төслийг эцэслэн боловсруулж засаад баримт бичгийг батлуулахыг удирдлагын хэсэг гишүүдэд даалгажээ. Гэвч И.Сталиныг оршуулах ёслолд оролцохоор маргааш нь Москва явахынхаа өмнө тэр тогтоолыг батлах хэрэггүй гэсэн байна. Тэрбээр уул асуудлаар Москватай зөвлөж тийм шийдвэр гаргахаас татгалз гэсэн зөвлөмж авсан гэж үзэх үндэстэй>>¹⁰ хэмээн бичжээ.

Ямар ч байсан уул асуудлыг хэлэлцээд гаргасан тогтоол, эсхүл түүний төсөл ЗХУ-ын дээд удирдлагуудад хүрсэн тул 1953 оны 3.дугаар сарын 8-нд В.Молотов Ю.Цэдэнбалтай уулзаж ярилцахдаа: “ЗСБНХУ-д нэгдэх гэсэн асуудлын тань талаар Тантай ярихыг надад даалгасан юм. Одоо бол цаг нь бишээ. Зөвлөлтийн империализмын тухай дахиад л ярьцгаах болно. Энэ шийдвэрээ цуцлах хэрэгтэй. Гэхдээ яахав, цуцлах л болж дээ. Танай энэ шийдвэрээс чинь болчимгүй зан ханхалж байна. Анхнаасаа зөвлөж ярих хэрэгтэй байсан шүү дээ... Ер нь танайд нэг нь нөгөөгөөсөө илүү зүүн тийш хэлбийх юм”¹¹ гэжээ.

Энэ ярианаас анхаарал татаж байгаа зүйл нь “Одоо бол цаг нь бишээ” гэсэн үг юм. Энэ нь ихээхэн учиртай, алсын зорилго бүхий санаа байсныг түүх сүүлд тайлж өгсөн билээ.

Дэлхийн II дайн дууссаны дараа улс төрийн газрын зурагт том өөрчлөлт гарч, олон үндэстэн эрх чөлөөтэй болж шинэ улс гүрнүүд байгуулагдсан, мөн <<халуун>> дайн <<хүйтэн>> дайнаар солигдсон зэрэг үйл явдлууд олон улсын байдалд шинэ уур амьсгал бий болгосон юм. Энэ мэт хувьсал, өөрчлөлтийн дагуу Монгол улсын удирдагч Ю.Цэдэнбал ЗХУ-д нэгдэж орох гэсэн саналыг дэмжиж байсан анхныхаа бодлоос эрс татгалзаж Монгол улсынхаа тусгаар тогтнолын асуудлаар гуйвшгүй хатуу байр суурьтай болсон байна. Үүнийг батлах хэдэн жишээ татъя.

В.Молотовын дээрх ярианаас хойш 20 жилийн дараа 1973 онд Л.И.Брежнев, Ю.Цэдэнбалтай Крымд уулзахдаа Болгарын удирдагч Т.Живков ЗХУ-д нэгдэн орох

⁹ М.С.Капица. Дипломатчийн тэмдэглэл

¹⁰ Ш.Г.Надиров, <<Цеденбал. 1984 год. Москва. 43,44дэх тал

¹¹ Гэрэл сүүдэр: Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс. Улаанбаатар.1992он

тухай шийдвэр гаргаснаа бидэнд саяхан мэдэгдлээ гэж хэлээд түүний бодол санааг тандсан байна. Гэтэл Ю.Цэдэнбал тэр тухай юу ч хэлэлгүй өнгөрч байжээ. Үүнээс хойш 3 жилийн дараа бас дахин санааг нь тандаад үзсэн байна. Энэ талаар Ю.Цэдэнбал хувийн тэмдэглэлдээ бичиж үлдээснийг нь сийрүүлбэл: <<Варнад амарч байхад 76 оны 8 дугаар сарын 21 нд Зөвлөлтийн Элчин сайд Владимир Эркульевич Пазовский далайн эрэг дээр надад дор дурдсан зүйлийг хэлсэн. Үүнд: Нөхөр Живков Болгарыг Зөвлөлт улстай нэгтгэх асуудлыг тавьж байгаа юм. Нөхөр Брежнев 73 онд энд ирээд хариулахдаа Югослав, Румыныхэн буруу ойлгож магад. Та нар яарах хэрэггүй. Танай улсын өмнө талд урьд эрх чөлөөгөө олсон Монгол улс байгаа юм... Тэд яараагүй байна шүү дээ хэмээсэн юм гэв. (Би үүнийг сонсоод өнгөрөв. Ямар нэгэн зүйл хэлээгүй)>>¹² гэсэн байдаг.

Энэ бүгдээс дүгнэлт хийвэл Л.Брежнев эхлээд Монголыг ЗХУ-д нэгтгэх, тэгэхдээ яарахгүй, үйл явцын дундуур аажим шийднэ гэж бодож байжээ. Ийнхүү В.Молотов, Л.Брежнев хоёр Монголыг яваандаа ЗХУ-д нэгтгэх санаархалтай байсан гэж үзэх үндэстэй.

Болгарыг ЗХУ-тай нэгтгэх гэсэн Болгар-Зөвлөлтийн удирдагчдын сэтгэлийн хөөрөлд Ю.Цэдэнбал автагдаагүй бөгөөд нэг улсыг нөгөөтэй нь урьдаар нэгтгэх биш, эхлээд эдийн засгийн талаар ойртуулан нягтруулах нь чухал гэсэн байр суурьтай байжээ. Энэ талаар ЗХУ-ын дипломатч Ш.Г.Надилов бичихдээ “Социалист орнуудыг бүх талаар ойртуулан нягтруулах зарим арга хэмжээний тухай ЗХУКН-ын Төв Хороо, СнЗ-ийн тогтоолын талаар танилцуулахад минь хэд хэдэн санаа хэлээд танилцуулсан бичгийн буланд “БНМАУ-ын тусгаар тогтнол, бие даасан байдлыг хадгалсан нөхцөлд”¹³ гэсэн цохолт хийсэн билээ хэмээн тэмдэглэсэн байдаг.

Энэ нь Ю.Цэдэнбал ЗХУ-ыг эрхэмлэн дээдлэж, түүний дэмжлэг тусламжинд тулгуурлан улс орноо хөгжүүлж байсан боловч Москвагийн зааврыг тэр бүр хүлээж аваагүй, эвтэйхэн зайлсхийх арга сүвэгчилж чаддаг байсных нь нэг илрэл бизээ.

Ю.Цэдэнбалын гадаад бодлогын бас нэг чухал чиглэл нь тэр үеийн “хүйтэн дайны” нөхцөл, ЗХУ, БНХАУ-ын хооронд нэн хурцадмал байдал үүссэн түгшүүртэй цаг мөчид Монгол улсынхаа тусгаар тогтнолыг улс төр, дипломатын аргаар Хятадын санаархлаас хамгаалах асуудал байлаа. 1960-1970-аад оны үед ЗХУ, БНХАУ-ын

¹² Гэрэл сүүдэр: Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс. Улаанбаатар 1992 он. 100 дахи тал.

¹³ Ш.Г.Надилов, Цеденбал. 1984 год. Москва. 1995. 45 дахи тал

харилцаа эрс муудаж зэвсэгт мөргөлдөөн хийх болсон нөхцөлд Ю.Цэдэнбал ЗХУ-д хандан зөвлөлтийн цэрэг, байлдааны зэвсэг техникийг Монголд оруулж байсан билээ.

БНХАУ-ын удирдагчдаас БНМАУ-ын тусгаар тогтнолыг үл ойшоон явуулж байсан бодлогын эсрэг Ю.Цэдэнбал ийнхүү тууштай тэмцэж байсан юм.

ЗХУ-ын байдал 1980-аад оны дундуур нилээд түвэгтэй болсон тул дотоод, гадаад бодлогодоо эрс шийдвэртэй өөрчлөлт хийх алхмыг анх эхэлсэн М.С.Горбачев тэргүүтэй шинэ лидерүүдэд Ю.Цэдэнбалын Хятадын эсрэг хатуу байр суурь нь төдий л таашаагдаагүй гэдгийг ЗХУ-д Элчин сайд байсан миний бие ямар нэг хэмжээгээр гадарлаж байсан бөгөөд БНМАУ-тай харилцаагаа хэвийн байдалд оруулахын тулд Хятадын талын шаардлагаар арга буюу Ю.Цэдэнбалыг өөрчлөх, Зөвлөлтийнхөө нэрд гарсан хятад судлаачдын заримыг халж солих алхам хийсэн болов уу гэж би хувьдаа боддог.

Эцэст нь тэмдэглэхэд Ю.Цэдэнбал Монгол улсын удирдагч байсан жилүүдэд дэлхий ертөнц цэрэг-улс төрийн хоёр бүлэглэлд хуваагдан үзэл суртлын “хүйтэн дайн” дэгдээсэн төдийгүй, түүхэнд хамгийн их цус урсгасан “халуун дайн” шатаасан, бас манай хоёр аварга хөршүүд маань дайсан хэмээн бие биенээ үзэж чадахаа болиод үе үе буун дуу гаргадаг болсон, ЗХУ-ыг эрхэмлэн шүтсээр яваад эцэстээ өөрөө Кремлийн хяналтад орсон зэрэг нэн ээдрээтэй, эгзэгтэй нөхцөл байдалд тэрбээр тусгаар тогтнолоо тууштай хамгаалсаар улсаа НҮБ-д гишүүнээр элсүүлснээс гадна, “БНМАУ-ЗСБНХУ-БНХАУ” гэсэн гурвалсан холбооны сүлжээнд хүч мөхөс гүрнийхээ язгуур эрх ашиг, стратегийн сонирхлыг туйлбартай хамгаалсан идэвхтэй гадаад бодлого явуулж хэрэгжүүлсэн тул Монгол Улсын XX зууны төрийн нэрт зүтгэлтэн, цогт эх оронч, дэлхийд нэртэй улс төрч мөн бөлгөө.

Энэ өгүүллийг бичиж дууссанахаа дараа нэг баримт олж үзэв. Тодруулбаас, 1934 оны 7 дугаар сард ЗХУ-ын гадаад хэргийн ардын комиссириатын орлогч Л.М.Карахан тусгай даалгавар биелүүлэхээр Монголд ирж ажиллаад буцсанахаа дараа Москва дахь АНУ-ын элчин сайдад ярихдаа: <<Намайг тэнд айлчлах үед Монгол улс Зөвлөлт Холбоот Улсад нэгдэхийг дахин хүссэн, мэдээж “большевик империализм” гэж нэрлэгдэх үйл ажиллагаагаар энэхүү мөчид зарим орныг айлгахгүйн тулд өмнөх 6 хүсэлтийг татгалзсаны нэгэн адил ЗХУ энэхүү хүсэлтийг ч татгалзлаа. Монголын одоогийн байдал бидэнд илүү тохиромжтой байна>>¹⁴ гэж хэлж байжээ. Эндээс үзвэл Монгол улсыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах саналыг

¹⁴ North-East Asian Studies, Ulaanbaatar. 1996.№2(8)

1944 оноос 1950 оны 3 дугаар сар хүртлэх хугацаанд дээр дурьдсан нэр бүхий хүмүүс тавьж түүнийг нь Ю.Цэдэнбал нэгэн үе дэмжиж байсан явдал цоо шинэ зүйл биш ажээ. Иймээс “Ю.Цэдэнбал бол Монгол улсыг ЗХУ-ын 16 дахь республик болгох гэсэн урвагч” хэмээн ганцхан түүнийг буруутган хараан зүхэж байсан нь уул асуудлыг хэт улс төржүүлсэн гүтгэлэг гэдэг нь улам ч тодорхой болж байна.

Өгүүлэлд дурьдсан хүмүүсийн тухай товч тайлбар:

1. **Ю.Цэдэнбал.** 1940-1984 онуудад БНМАУ-ын нам, төрийн тэргүүн байсан бөгөөд түүнийг өвчний учир <<өөрийн нь зөвшөөрснөөр>> гэсэн тайлбар хийн 1984 оны 8 дугаар сард бүх албан тушаалаас нь чөлөөлж тэтгэвэрт гаргасан боловч 1990 оны 3 дугаар сард намаас нь хөөсөн ба баатар, маршал цолыг нь хүчингүй болгосон. 1991 онд тэрбээр Москва хотноо нас нөхцсөн бөгөөд түүнээс хойш нилээд хэдэн жилийн дараа өмнөх бүх шийтгэл, зэмлэлийг хүчингүй болгож нэр алдрыг нь сэргээсэн.
2. **Х.Чойбалсан.** 1930-аад оны дундаас 1952 он хүртлэх хугацаанд БНМАУ-ын Ерөнхий сайд, Дотоод яамны сайд, Гадаад явдлын яамны сайд, Батлан хамгаалах яамны сайд зэрэг албыг хэсэг хугацаанд нэгэн зэрэг хашиж байсан. 1930-аад онд олон мянган хүнийг Японы тагнуул, хувьсгалын эсэргүү гэсэн улс төрийн хилс хэрэг тулгаж цаазлан хороох ажлыг удирдаж байсан ба хоёр Ерөнхий сайд зэрэг том тушаалын хүмүүсээ баривчлан Москвад явуулж Зөвлөлтийн хуулиар цаазлуулж байсан. Өрлөг жанжин (маршал) цолтой, хошой баатар. И.Сталинтай байнга уулзаж зөвлөгөө, заавар авдаг байсан бөгөөд 1949 оны 9 дүгээр сарын эцсээр түүнтэй сүүлчийн удаа уулзсан. И.Сталиныг нас барахаас нэг жилийн өмнө 1952 онд Москва хотноо өөд болсон.
3. **Д.Төмөр-Очир.** ЗХУ-д боловсрол эзэмшсэн, философийн ухааны доктор, улс төрийн зүтгэлтэн. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны гишүүн, НТХ-ны нарийн бичгийн даргын өндөр алба хашиж байгаад 1962 онд халагдсан. Чойбалсан өөрийгөө хэт ихээр тахин шүтүүлж байсан, олон хүнийг хэлмэгдүүлснийг хурцаар шүүмжилдэг байснаас гадна Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойгоор түүнд анх удаа хөшөө босгосон, үндсэрхэг үзэл гаргасан гэх зэргээр түүнийг буруушаан шийтгэсэн. Дараа нь Дархан

хотод амьдарч байгаад 1985 оны 10 дугаар сард өөрийнхөө гэрт нэн сэжигтэйгээр бусдад хорлогдож нас нөхсөн.

4. **Л.Цэнд.** ЗХУ-д боловсрол эзэмшсэн, эдийн засгийн ухааны доктор, улс төрийн зүтгэлтэн. МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, НТХ-ны хоёрдугаар нарийн бичгийн дарга байсан. Энэ нь Ю.Цэдэнбалыг шууд залгамжлах магадлалтай албан тушаал бөгөөд түүний хамгийн аюултай өрсөлдөгч гэж хэлж болно. Нэг хүнийг тахин шүтэхийн эсрэг шүүмжлэл өрнүүлэхдээ Л.Цэнд зөвхөн Х.Чойбалсан төдийгүй мөн Ю.Цэдэнбалыг ч хамруулахыг завдсан, түүний улс орныг удирдаж зохион байгуулах арга, чадвар хоцрогдсон талаар ЗХУКН-ын удирдлагад мэдэгдэж дэмжлэг авахыг оролдсон гэх зэргээр шүүмжилж 1963 оны 12 дугаар сард бүх албан тушаалаас нь огцруулан Мод боловсруулах комбинатын дарга болгосон.
5. **Б.Жамбалдорж.** 1950-аад оны үед МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн товчооны гишүүн, Монгол улсын Ерөнхий прокурорын алба хашиж байсан, нилээд хатуу чанга хууль боловсруулдаг нэгэн. Мөн БНМАУ-ыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах санал анх тавьсан. В.Молотов хэлэхдээ: <<... юутай ч гэсэн улс төрийн бодлоготны хувьд тааруухан хүн юм даа. Та нар жаахан автагдсан байна>> гэсэн байдаг.
6. **Салчик Тока.** Монгол улсын баруун хойд хязгаар нутгынхан 1921 онд Бүгд найрамдах Тува ард улс болж Монголоос салан тусгаарлаж бие даасан бөгөөд улмаар С.Токагийн шууд удирдлага, санаачлагаар 1944 онд ЗХУ-ын бүрэлдэхүүнд орж, дараа нь нэгэн автономит муж болсноор энэ улсыг дэлхийн газрын зурагт тэмдэглэхээ больсон түүхтэй.

The paper covers several occasions where Mongolian leaders proposed the country's merger with the Soviet Union. Previously classified information is used to examine each individual's stance on the question of Mongolia's independence.

Romanization:

This article uses conventional form of transliteration of Mongolian Cyrillic letter into Roman, using the consonants "kh," "ch," "ts" and "sh" as single letters and using separate letters to describe vowels "o" and "ti" apart from "ö" and "u."